



Сурталчилгаа- хүмүүжлийн ажил

Улсын хил хамгаалалтын ёс суртахуун-сэтгэл зүйн хангалт.

Цэргийн аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд оюун санааны хүч, ёс суртахууны хүчин зүйл чухал хэмээн үзэж, энэ асуудалд их анхаарч байсан нь эртний бичиг судар, хууль сургаал, түүнчлэн зохиол бүтээлүүдэд тусгалаа олж иржээ. Цэргийн ёс суртахуун-сэтгэл зүйн асуудалд эзэн богд Чингис хаанаас авахуулаад тухайлбал А.В.Суворов, М.И.Кутузов, Ф.Ф.Ушаков, М.И.Драгомиров нарын зэрэг Оросын нэрт жанжинууд ихээхэн анхаарал хандуулж байжээ.

XIX зууны II хагас, XX зууны эхээр Оросын цэргийн онолчид, судлаачид ёс суртахууны хүчин зүйлд шинжилгээ судалгаа явуулж, цэргийн байлдах чадвар, алба, үйл ажиллагаанд түүний үзүүлэх нөлөөг судалж мэдэгдэхүйц үр дүнд хүрсэн байна.

Тэр үеийн цэргийн шинжлэх ухаан цэргийн алба, байлдааны үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн иж бүрэн арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь ёс суртахуун-сэтгэл зүйн асуудал хэмээн үзэж түүний онол-практикийн чухал асуудлыг боловсруулжээ. Гагцхүү бие бүрэлдэхүүнд ёс суртахуун-сэтгэл зүйн шаардлагатай чанаруудыг төлөвшүүлэх зорилгоор бие хүн бөгөөд хамт олонд нөлөөлөх иж бүрэн арга хэмжээг боловсруулахад шинжлэх ухаанчаар хандах хандлага сул байсаар байна.

Түүгээр ч барахгүй тухайн асуудлыг шийдвэрлэх чиглэл хандлагыг сонгон авсан боловч нэг намын монопольчлол нэг үзэл суртлын дарангуйллын уршгаар бие хүн, хамт олонд дэс дугаартай, иж бүрнээр, шинжлэх ухаанч үндэстэй, тэдний алба үйл ажиллагаанд шаардлагатай ёс суртахуун" сэтгэл зүйн чанаруудыг төлөвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм. Энэ үед дэлхий ертөнц капиталист, социалист гэсэн хоёр хуваагдалд байсны улмаас тухайн үедээ бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн хатуужилтай болгож боловсруулдаг чадвартай америкийн сургуулийг хөрөнгөтнийх хэмээн шүүмжилж түүнд шинжлэх үүднээс хандахыг орхигдуулж байв.

"Ёс суртахуун" сэтгэл зүйн хангалт" гэдэг ойлголтыг XX зууны

80-аад оны дунд үеэс В.И.Лениний нэрэмжит цэрэг-улс төрийн академийн /тэр үеийн нэрээр/ эрдэмтэд, судлаачид, сурган хүмүүжүүлэгчид шинжлэх ухаанч судалгааны бие даасан салбар болгон хөгжүүлж ирсэн билээ.

Энэ ойлголтын уг чанар хөгжлийнхээ янз бүрийн үе шатуудад "нэр төрийн хууль", "зан суртахууны элемент", "оюун санааны тал", "цэргийн зан суртахууны уян хатан чанар", "армийн оюун санааны сүнс", "ёс суртахууны хүмүүжил", "ёс суртахуун-сэтгэл зүйн хүчин зүйл", "ёс суртахуун-сэтгэл зүйн үндэс", "ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл" гэхчилэн нэрлэгдсээр иржээ. Бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэлийн үзэл суртлын үндсийг Марксизм-Ленинизм, ангич, намч байр суурь, социалист эх орноо хамгаалах тухай Лениний сургаал, цэргийн байгуулалтыг удирдах намын удирдлага гэж томьёолж байсан юм. Гэлээ ч гэсэн цэргийн оюун санааны хүмүүжил болон сэтгэл зүйн хатуужлын үзэл суртлын үндсийг тодорхойлоход үндсэн өөрчлөлтүүд гарсан ч түүний голт зүрх нь бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн хатуужлыг бэхжүүлэх асуудал гэж үзсээр ирэв.

Монгол Улсын Хилийн Цэрэгт бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэлийг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх асуудал 70-аад оны дунд үеэс эхэлж зарим эрдэмтэд, судлаачид, практик ажилтнууд хэд хэдэн ном товхимол бичиж, орчуулж, хэвлүүлсэн нь зохих үр дүнгээ өгсөн юм.

Монгол Улсын хил хамгаалах байгууллагын алба үйл ажиллагааны ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтыг улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах бүх талын хангалтын бие даасан хэлбэр, нэн чухал үйл ажиллагаа гэж үзэх ёстой.

Иймээс өнөөдөр хилийн цэрэгт менежментийн хоцрогдсон арга хэлбэрээр зохиогдож буй сурталчилгаа соёл хүмүүжлийн ажлыг өөрчлөн шинэчлэх, өнөөгийн амьдралын бодит байдалтай нийцүүлэх шаардлага амьдралаар дэвшигдэн гарч ирсэн юм.

Өнөөдөр Монгол Улсын Хилийн Цэрэгт зохиогдож буй хүмүүжлийн ажлыг өөрчлөн шинэчлэх болсон шаардлагыг дараахь байдлаар тайлбарлаж байна.

Дэлхийчлэл бүх ертөнцийг хамарч гариг ертөнцийн юмс үзэгдэл танигдахгүй болтлоо өөрчлөгдөв. Өнөөдрийн юмс үзэгдлийг хуучнаар ойлгох аргагүй болов. Бидний ягштал баримталж боловсорч хүмүүжиж ирсэн онолын сэтгэлгээ үзэл баримтлал өөр болжээ. Ийм онол, сэтгэлгээгээр одоогийн өнөөдрийн хүмүүстэй ажиллаж болохгүй болсон.

Ер нь хүмүүсийн оюун санааг удирдах явдал үе үеийн

тулгамдсан асуудал байсан. Бидний төрж өсч, амьдарч ирсэн нийгэмд бас л үүнийг эрэлхийлж байлаа. Одоо ч эрэлхийлсээр л байна.

Иймээс ч цэргийн дотор зохиох нам улс төрийн ажил гэдэг үзэл баримтлал гарч, дараа нь бүр шинжлэх ухааны судалгааны бие даасан салбар болон хөгжиж энэ ажлын үр дүн нь сорилт шалгалтуудыг даван туулж, хүмүүсийн оюун санааны асар их хүчтэй зэвсэг болохоо харуулсан юм. Монголын Хилийн Цэрэгт ч энэ ажил хүчтэй байсныг түүх гэрчилнэ.

Хүн төрөлхтний хөгжлийн жам ёсоор дэлхийн социалист систем задарч хүйтэн дайн эцэслэн улс хоорондын харилцаанд шинэ хандлага буй олсон шинэ үед шилжин орохдоо монголын төр засаг ямар алдаа гаргав гэвэл:

-Намын үзэл суртлын ажил гэдгийг, жам ёсоор байр суурь-нөлөөгөө алдсан намтай нь хамт өгүүтгэсэн нь төрийн хүмүүжил сурталчилгааны ажил гэдэг хурц зэвсгээ "хураалгасантай" адил болсон. Энэ нь зорилго чиглэлгүй удирдлага, агуулга ач холбогдлоо алдаж, зөвхөн мэдээлэл сурталчилгаа-ухуулгын үйл ажиллагаа болдгийг харуулав.

-Зарим судлаачдын үзэж байгаагаар дэлхийн III дайн гэж нэрлэгдэх бүх нийтийн мэдээллийн дайнд монголчууд бид нэрвэгдэжнхордож үүний уршгаар хүн амын зарим хэсэг ёс суртахуун-сэтгэл зүйн хувьд доройтож эх оронч байх нь бүү хэл эх орноо орхих, ижил нөхдөө хөнөөх хүртлээ зэрлэгшсэн.

-Хууль ёс суларч, танхай балмад байдал гаарч монголын нийгэм гэмт хэргийн шинж төрхтэй болсноос хүмүүс зандалчдын гарт амиа алдах, өөрийн амийг өөрөө хөнөөх, осол аваарт өртөх, архинд донтож эрүүл мэндээ бусниулах зэргээр монголчууд дотроосоо "сугачаа хорогдол"-ын гамшигт унав.

-Хилийн Цэргийн бие бүрэлдэхүүнийг өндөр ухамсар сахилгатай, эх оронч эрэлхэг хилчин болгон хүмүүжүүлэх зорилготой улс төр, хүмүүжлийн ажил, онол, үзэл суртал, агуулгын хувьд хоцрогдож, хуучирсан менежмент бүхий "сурталчилгаа соёл мэдээллийн" гэгдэх шоовдор алба болсон.

-Дээр нь төрийн хүмүүжлийн чухал албыг удирдан зохион байгуулдаг газар, хэлтсүүдийг нь татан буулгаж, энэ албыг өөрөө тодорхой ажилтай штабын үйл ажиллагааны хавсарга болгож, энэ чиглэлээр гадаад дотоодод академи, дээд сургуульд суралцаж бэлтгэгдсэн мэргэжлийн ажилтнуудыг нь өөр ажилд шилжүүлэх буюу халж сэлгэж, бэлтгэн гаргадаг ХЦДС-ийн тэнхимийг нь татан буулгаж устгасан.

-Өнөөдөр төрийн суртал ухуулга, хүмүүжлийн ажлыг шат бүхэнд удирдан зохион байгуулах боловсон хүчин Хилийн Цэрэгт ихээхэн дутагдалтай болсон. Ийм ядмаг алба, ажил хоёроор мэдээллийн дайнд нэрвэгдсэгсдийг эх оронч эрэлхэг хилчин болгон хүмүүжүүлэх боломжгүйн дээр хилчдийг ёс суртахуун сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй болгон боловсруулж чадахгүй болжээ.

Улсын хил хамгаалалтад нөөөлөх хамгийн гол хүчин зүйл нь түүнд оролцож буй хилчдийн хүчин зүйл бөгөөд хил хамгаалах бодлогын төвд хүнийг тавьж түүний сэтгэл зүрхийг эзэмдэн жолоодож, түүнийг ёс суртахуун-сэтгэл зүйн хувьд бэлтгэх явдал чухал болоод байна. Гэтэл Монгол орны нөхцөлд эх орноо хамгаалах нь ариун үүрэг байх ёстой цэргийн алба ядуу зүдүү, боловсролгүй, ажилгүй хүний алба болсонтой холбоотойгоор, мэдээллийн дайнд шууд өртөх орон зайд амьдраагүй, нийгэм улс төрийн бодит байдлын хувьд дэндүү "атаршсан", оюуны соёлын их цөлжилтөд өртсөн залуучуудын гологдмол хэсэг хилд алба хаах болов.

Эдгээр байдлаас шалтгаалаад хилийн цэргийн бие бүрэлдэхүүнтэй зохиох сурталчилгаа соёл хүмүүжлийн ажлын удирдлагын менежмент зохион байгуулалтын оновчтой бүтцийг эрэлхийлэх, зохиох ажлын агуулгыг нь өнөөгийн бодит байдалтай уялдуулан өөрчлөн шинэчлэх шаардлагатай болов. Энэ зорилгын үүднээс "Монгол Улсын хил хамгаалалтын албаны бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар" гэдэг баримт бичгийг боловсруулаад байна.

Өнөөдөр бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн хангалт бол улсын хил хамгаалалтын бүх талын хангалтын цоо шинэ төрөл болж байна. Энэ нь тайван цагт болон хилийн цагийн байдлын хүндэрсэн нөхцөлд улсын хилийг манаж, хамгаалах үүргийг биелүүлэхэд шаардлагатай түвшинд Монгол Улсын хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүн, нийт ард иргэдийн ёс суртахуун-сэтгэл зүйн тогтвортой байдлыг барьж байх зорилгоор улс орны төр засаг, цэргийн удирдлага, албан тушаалтнуудын үйл ажиллагааг зохицуулсан цогц арга хэмжээ мөн.

Монгол Улсын хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл бол тэдгээрийн ухамсарт үйл ажиллагаа, үзэл бодол, сэхээрэл, сэтгэхүйд илэрч байдаг, алба үйл ажиллагааны зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх чадвар, дотоод бэлэн байдал мөн.

Монгол Улсын хил хамгаалалт нь эдүгээ бие бүрэлдэхүүний бие бялдар сэтгэл санааны ачаалал өсөн нэмэгдсэн, мэдээлэл сэтгэл

зүйн тэмцэл хурцадсан нөхцөлд явагдаж байна. Монгол Улсын хилийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх чадвар нь хүний сэтгэхүйн үйлдлийн зүй тогтолтой уялдаатай явагдах бөгөөд бие бүрэлдэхүүний ёс суртахуун сэтгэл зүйн байдлын түвшингээр хэмжигдэнэ. Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалт нь тайван цагт болон цагийн байдал хурцадсан үед улсын хилийг хамгаалах үйл ажиллагааны зорилтыг биелүүлэхэд анги салбаруудын удирдлага, албан тушаалтнуудаас явуулах төрийн удирдлагын үйл ажиллагааны цогц асуудал юм.

Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтын зорилго нь:

Хил хамгаалах албаны үйл ажиллагааг амжилттай шийдвэрлэхэд бие бүрэлдэхүүний ёс суртахууны өндөр чанар, сэтгэл зүйн бэлэн байдлыг төлөвшүүлэх, тэдний ёс суртахуун-сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах, сахилга дэг журам, зохион байгуулалтыг бэхжүүлэх, хамт олны дотор ажил хэрэгч, эвсэг найрсаг, харилцан туслалцдаг уур амьсгал бүрдүүлэх, мэдээлэл-сэтгэл зүйн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэхэд бие бүрэлдэхүүнийг бэлэн байлгахад оршино.

Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтын үндсэн зорилтууд:

- Үндсэн хууль болон төрийн бусад хууль тогтоомж, өргөсөн тангараг, ангийнхаа туг, хилийн цэргийн дайчин уламжлалд үнэнч, эрэлхэг зоригтой, эх орныхоо төлөө амь хайргүй тэмцэгч байх үзэл санаагаар хүмүүжүүлэх үндсэн дээр бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын төр засгийн бодлого шийдвэрийг хилийн цэргийн бие бүрэлдэхүүн, хязгаар нутагт оршин суугчдад цаг тухайд нь шуурхай хүргэх, дэлхий нийтийн болон бүс нутаг, хил хязгаарын цэрэг улс төрийн болон хилийн цагийн байдалтай уялдуулан улсын хилийг хамгаалах зорилтыг тайлбарлан сурталчлах,
- Улсынхаа хилийг хамгаалах алба үйл ажиллагаанд эзлэх байр суурь гүйцэтгэх үүргээ мэдэж ухамсарлан, түүнийг зоригтой, шийдэмгий, хариуцлагатай гүйцэтгэхэд бэлэн байх чадвартай болгох,
- Хамт олны нэгдэл нягтралыг хангах, чанд хатуу сахилгыг тогтоох, хууль дүрэм, тушаал шийдвэрийг ягштал биелүүлэх, чадвартай, гүйцэтгэгч, зохион байгуулагч болгон хүмүүжүүлэх,
- Улсын хилийн хариуцсан хэсэг, хязгаар нутагт бий болсон цагийн байдлын өөрчлөлтийг тасралтгүй мэдээлэх, захирагч /дарга/ нарын удирдамж, тушаалыг цаг алдалгүй хүргэж, түүнийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Бие бүрэлдэхүүний амьдрал, үйл ажиллагааны нийгмийн болон эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оролцох, тэдгээрийн хууль ёсны эрхийн баталгааг хангах, өндөр зохион байгуулалт, сахилга, дэг журмыг тогтоох,

● Улсын хил, хязгаар нутагт нийгэм-улс төрийн таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төр захиргаа, аж ахуйн нэгжийн удирдлага субъектүүдтэй холбоо тогтоож нягт харилцан ажиллаж, хил хамгаалалтын алба үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхийн тулд орон нутгийн нөөц, давуу талд түшиглэх,

● Бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх, тэдэнд сэтгэл санааны тогтвортой байдлыг төлөвшүүлэн, албаны зорилтуудыг хэрэгжүүлэхэд бэлэн байлгаж, сэтгэл санаанд нь сөрөг нөлөөлөх хүчин зүйлүүдийг даван туулахад нь туслах,

● Эсрэг талаас явуулж болох сэтгэл зүйн сөрөг нөлөөллийг няцаах, тэдгээрийг мэдээлэл сэтгэл зүйн явууллагаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг нь таслан зогсоох арга хэмжээг авах,

● Бие бүрэлдэхүүний амралт-чөлөөт цагийг зөв зохион байгуулах, тэдний сэтгэл санааг эрүүл саруул байлгах,

● Хэвлэл мэдээллийн ажлыг зохион байгуулах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг идэвхижүүлэх, хил хамгаалах байгууллагыг ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтыг техник хэрэгслээр хангах, тэдгээрийг тухай бүрд нь засч шинэчилж байх,

Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалт нь улсын хил, хязгаар нутагт үүссэн цагийн байдлын өөрчлөлт, алба үйл ажиллагааны зорилго, зорилтуудтай уялдуулж тасралтгүй явуулснаар хэрэгжих бөгөөд түүний үр дүн:

● Алба-үйл ажиллагааны зорилтуудыг биелүүлэх нийгэм-улс төрийн нөхцөл байдлын тухай мэдээг байнга цуглуулах, тэдгээрийг судалж, дүн шинжилгээ хийж, үнэн зөв үнэлгээ өгөх,

● Ёс суртахуун –сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах зорилтыг биелүүлэхэд цаг үеэ олсон, үндэслэлтэй шийдвэр гаргаж, оновчтой төлөвлөх, үүсч буй цагийн байдалтай уялдуулан түүний үр ашигтай хэлбэр, арга хэрэгслийг сонгож хэрэглэх,

● Хил хамгаалалтын албаны зорилтуудыг шийдвэрлэхэд бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн талаар бэлтгэхэд бүх шатны захирагч /дарга/ нар штабууд, сурталчилгаа хүмүүжлийн болон цэргийн удирдлагын бусад нэгжүүдтэй байнгын нягт харилцан ажиллаж, зохион байгуулалтын үйл ажиллагааг тасралтгүй, идэвхитэй явуулах

● Бие бүрэлдэхүүний ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын зорилтуудыг шийдвэрлэхэд захирагч /дарга/ нар болон бусад албан тушаалтнуудыг сургаж дадлагажуулах,

● Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтын практик үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техникийн орчин үеийн ололтыг ашиглах, бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн байдлыг судлах арга зүй,

технологийг эзэмших,

● Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалтын ашиг сонирхолын хүрээнд хил хамгаалах байгууллагын анги, салбарууд, орон нутгийн төр захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй тогтмол харилцан ажиллах,

● Ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын хүч хэрэгслийг тасралтгүй зохион байгуулах явдлаар хэмжигдэнэ.

Ёс суртахуун-сэтгэл зүйн хангалт нь:

- Мэдээлэл сурталчилгааны
- Ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэлийн,
- Хууль эрх зүйн
- Амралт-чөлөөт цагаар зохиох соёл хүмүүжлийн болон сөрөг суртал нэвтрүүлгийн ажлуудаас бүрдэнэ.

Мэдээлэл сурталчилгааны ажил.

Бие бүрэлдэхүүнтэй зохиох мэдээлэл сурталчилгааны ажил бол тэдний эх оронч, хилч сэтгэлгээг хөгжүүлэх, үе үеийн шилдэг эх орончдын баатарлаг дайчин уламжлалд үнэнч байх, эх орныхоо хилийг хамгаалах, иргэний болон цэргийн үүргээ биелүүлэхэд сонор сэрэмжтэй, сахилгатай, эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтай, шийдэмгий болгон хүмүүжүүлэхэд чиглэгдсэн бүх шатны захирагч дарга, штабууд болон хил хамгаалах бусад байгууллагуудын зохион байгуулалт, мэдээлэл хүмүүжлийн зорилго чиглэл бүхий байнгын үйл ажиллагаа мөн.

Мэдээлэл сурталчилгааны ажлын үндсэн зорилтууд нь:

- Дэлхий дахины болон бүс нутгийн, улсын хил, хязгаар нутгийн цэрэг улс төрийн байдлын тухай мэдээ мэдээллийг цуглуулах, судлах, дүн шинжилгээ хийх,
- Алба үйл ажиллагааны бүх хэлбэрүүдэд даяарчлалын болон цэрэг улс төрийн мэдээллийн системийг нэвтрүүлэх,
- Бие бүрэлдэхүүнд амьдралын идэвхитэй байр суурийг төлөвшүүлэх, Монгол улсынхаа хилийг хамгаалах албанд зүтгэж байгаагаараа бахархах, хамтач үзэл, нөхөрсөг харьцаа, нэгэндээ туслах, хүмүүст хүнлэг энэрэнгүй хандах хүмүүжлийг төлөвшүүлэх,
- Нийгмийн амьдралын олон талт үзэгдэл, төрийн хилийн бодлогыг ойлгох, мэдрэмж, түүнийг үзэх үзэл хандлагыг бие бүрэлдэхүүнд төлөвшүүлэх,
- Төрийн хууль тогтоомж, цэргийн тангараг, дүрэм захирагч /дарга/

нарынхаа тушаалыг хүндэтгэн ухамсартай биелүүлдэг хүмүүжлээр бие бүрэлдэхүүнийг хүмүүжүүлэх,

● Бие бүрэлдэхүүний гоо зүйн таашаал, зан суртахууны соёлыг хөгжүүлэх,

● Мэдээлэл сурталчилгааны нөлөөллийг иж бүрнээр явуулах зорилгоор бие бүрэлдэхүүн, хилд алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн хүмүүст эх оронч ёс суртахуун цэргийн болон хууль эрх зүй, бие бялдар, экологийн хүмүүжлийг эзэмшүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл хүмүүжлийн ажлын арга хэлбэрийг байнга боловсронгуй болгох байх,

● Мэдээлэл сурталчилгааны ажлын зорилтуудыг хэрэгжүүлэхэд сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаанаар нотлогдсон, амьдрал практикаар шалгагдсан, бие бүрэлдэхүүний хурал, нийгэм, улс төрийн бэлтгэлийн хичээл, мэдээлэл, цуглаан, лекц, ярилцлага, тэргүүн туршлага солилцох, сэдэвт үдэшлэг, аман сэтгүүл, мэтгэлцээн, асуулт хариултын үдэшлэг, тэмцээн улс төрийн нэгдсэн өдөрлөг, техникийн болон спортын, компьютер, гадаад хэлний дугуйлан, ойн арга хэмжээг тэмдэглэх, цэргийн тангараг өргөх ёслол, цэрэг халах, татах үед зохиох ажил, ахмад хилчдийг чөлөөнд гарахад нь үдэх ажиллагаа, хилчдийн үе үеийнхэнтэй зохиох уулзалт зэрэг ажлын хэлбэрүүдийг бүтээлчээр ашиглах,

● Мэдээлэл хүмүүжлийн ажлын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төр, олон нийтийн болон соёл урлаг, шашны байгууллагуудтай холбоотой ажиллах,

Энэ зорилгоор соёлын байгууллагууд, музей, анги салбаруудын алдрын танхим, Монгол Улсын Хилийн Цэргийн түүхэн замнал, өнгөрсөн болон өнөөдрийн баатарлаг үйлсийг сурталчлах,

Бие бүрэлдэхүүнийг мэдээллээр хангана гэдэг нь хилчдийн амьдрал үйл ажиллагааны нийгэм, улс төр, албаны болон ахуйн шинж чанартай мэдээллийг хүргэх бүх шатны захирагч /дарга/ нар, төрийн сурталчилгаа, хүмүүжлийн байгууллагуудын удирдлагуудын хамтын үйл ажиллагаа юм.

Онол-эрх зүйн бэлтгэл нь бие бүрэлдэхүүнийг ёс суртахуун, сэтгэл зүйн талаар төлөвшүүлэх ажлын үндсэн хэлбэр юм. Энэ нь бие бүрэлдэхүүнд эх орныхоо дархан хилийг хамгаалахад ямагт бэлэн, өргөсөн тангарагтаа үнэнч, ёс суртахуун сэтгэл зүйн хатуужилтай, хатуу чанд сахилгатай байх, хил хамгаалах байгууллагын боловсон хүчний эрх зүй, сэтгэл судлал-сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдэх бөгөөд жил бүрийн хичээлийн хөтөлбөрт тусгагдаж байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашигласнаар теле болон

радиогийн нэвтрүүлэг, тогтмол хэвлэлүүдийн хүмүүжлийн нөлөөг буй болгох ёстой. Бие бүрэлдэхүүнийг бүх талын мэдээллээр шуурхай хангах ажлын үр нөлөө нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг иж бүрэн ашигласнаар хангагдана.

Үзүүлэн таниулах мэдээллийн хэрэгслийг ашиглах нь бие бүрэлдэхүүний амралт, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх зорилгоор хил хамгаалалтын байгууллагын салбар нэгжүүдэд мэдээллийн өрөө, тасалгаа байгуулж төхөөрөмжлөх, зурагт хуудас, самбар, уриа, ухуулах хуудас, цахилгаан мэдээ, дайчин хуудас, ханын сонин зэрэг үзүүлэн таниулах мэдээллийн хэлбэрүүдийг өргөн хэрэглэвэл зохино.

Бие бүрэлдэхүүнтэй зохиох ёс суртахуун сэтгэл зүйн бэлтгэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах нэгдсэн тогтолцоог бий болгоход бүх шатны захирагч /дарга/ штаб, албан тушаалтнуудын хүч чармайлтыг нэгтгэснээр тухайн ажил үр дүнд хүрнэ.

Ёс суртахуун – сэтгэл зүйн бэлтгэлийн ажил

Хил хамгаалах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхэд бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн талаар бэлтгэх тэдний ёс суртахуун-сэтгэл зүйн байдлыг судалж хөгжүүлэхэд чиглэгдсэн захирагч /дарга/, сурталчилгаа ёс суртахуун-сэтгэл зүйн хүмүүжлийн ажил хариуцсан албан тушаалтнуудын зорилго чиглэлтэй үйл ажиллагааны тогтолцоог ёс суртахуун сэтгэл зүйн бэлтгэлийн ажил гэнэ.

Ёс суртахуун-сэтгэл зүйн ажил нь хилийн цагийн байдлын янз бүрийн нөхцөлд улсын хил хамгаалах үүргийг биелүүлэхэд бие бүрэлдэхүүнийг санаа сэтгэлийн хувьд бэлтгэж төлөвшүүлэх, оюун санаа, сэтгэл зүйн ачааллыг даван туулах, сэтгэлийн тэнхээтэй байлгах зорилгоор зохион байгуулагдаж хэрэгжинэ. Ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл ажлыг явуулахад дараахь бүрэлдэхүүнд анхаарлаа чиглүүлнэ. Үүнд:

- Хил хамгаалах албанд зохицон дадах хүртлээ тохиолдох бэрхшээл зүдгүүртэй тулгарч буй шинэ дайчдад,
- Байнгын байрлалаасаа алсад тусгай үүрэг гүйцэтгэж байгаа бүлэг, манаа, харуул,
- Гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй офицер, ахлагч, түрүүч, цэргүүдэд,
- Ёс суртахуун-сэтгэл зүйн хувьд тааламжгүй уур амьсгал бий болсон хамт олон, харуул манааны бүрэлдэхүүнд тус тус анхаарвал зохино.

Ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэлийн ажлын үндсэн зорилтууд нь:

- Хилийн Цэргийн бие бүрэлдэхүүний үйл ажиллагааны сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох, тэдгээрийн зан суртахуун, оюун ухаан, зоригийн чанаруудыг хамт олны дэг журам, эмх цэгц, нэгдэл нягтралыг бэхжүүлэх,
- Алба үйл ажиллагааны тодорхой зорилтуудыг шийдвэрлэхэд хүч хэрэгслийг оновчтой зөв хуваарилах зорилгоор ялангуяа албанд шинээр ирэгсдийг сэтгэл зүйн талаар оношилж, нийгэм сэтгэл зүйн судалгаа явуулах,
- Танин мэдэхүй, сэтгэл санааны хувьд туйлбаргүй хүмүүсийг илрүүлж, тэднийг сурган хүмүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах,
- Хилийн суман, салбар, харуул, манааны бүрэлдэхүүний албаа гүйцэтгэх чадварыг сэтгэл зүйн талаар үнэлж, сэтгэл зүйн тохиргоог бүрдүүлэх,
- Нийгэм хүмүүнлэгийн тодорхой орчин, байгаль, газар зүй, цаг уурын нөхцөлд үүрэг гүйцэтгэх, анги, салбар манаа, харуулын бүрэлдэхүүнийг сэтгэл зүйн талаар бэлтгэх,
- Алба үйл ажиллагааны явцад бие бүрэлдэхүүнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх,
- Зэвсэгт тулгаралт болон сэтгэл зүйн ачаалал, хямралд орсон хүмүүсийг сэтгэл санааны талаар тайвшруулах,
- Хил хамгаалалтын онцгой даалгавар гүйцэтгэсэн тусгай бүлэг, харуул манааг томилж бүрдүүлэхэд сэтгэл зүйн талаар мэргэжлийн сонголт хийх зэрэг болно.

Ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл ажлын үндсэн хэлбэрүүд:

- Бие бүрэлдэхүүнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн талаар урам зоригийг нь дээшлүүлэх,
- Сэтгэл санааны хямралд орж болзошгүй хүмүүсийн сэтгэл санааны хямралтай үйлдлийг зогсоох буюу багасгах,
- Бие бүрэлдэхүүний сэтгэхүйн байдлыг оношилж, үйл ажиллагааг нь сэргээн тогтворжуулах,
- Алба үйл ажиллагааны болон сэтгэл санааны гүнзгий хямралд орогсдод тусламж үзүүлэх,
- Олон нийтийг хамарсан сэтгэхүйн зохисгүй үзэгдлийг таслан зогсоох зорилгоор түүнд өртөгдсөн хүмүүсийг тусгаарлаж, хяналтад авах,
- Бие бүрэлдэхүүний сэтгэл санааны байдлыг сэргээн нийгмийн өдөр тутмын харилцаанд аажмаар шилжүүлэн оруулах талаар сэтгэл зүйн ажил явуулах,
- Зэвсэгт халдлага болон бусад үйл ажиллагаа явагдсан газар оронд

сэргээн дасгах, гэр бүлийн хүмүүс болон хамт алба хааж буй нөхдийг байнгын байрлал дээр нь байлгаж, тэдний сэтгэл санааны эрүүл саруул байдлыг хангахад туслах, шархадсан, бэртсэн, сэтгэл санаагаар унасан хүмүүсийг эмчлэн, арчлан сувилахад нийгэм-сэтгэл зүйн тогтворжуулалтыг хийх бөгөөд энэ нь хилийн эмнэлгийн байгууллагуудад явагдана.

Хууль, эрх зүйн ажил

Хууль эрх зүйн ажил нь Хилийн Цэргийн бие бүрэлдэхүүний болон тэдний гэр бүлийн гишүүдэд хуулиар олгогдсон эрх, үзүүлэх хөнгөлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хүмүүжил зохион байгуулалтын арга хэмжээний тогтолцоо юм.

Монгол Улсын хил хамгаалах зорилтуудыг шийдвэрлэх явцад бие бүрэлдэхүүнээс албан үүргээ биелүүлэхийн тулд баримтлах нийгмийн нөхцөл хууль эрх зүйн баталгааг буй болгох зорилгоор хууль, эрх зүйн ажил явагдана. Хууль эрх зүйн ажлыг ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын ерөнхий төлөвлөгөөний нэг хэсэг болгон төлөвлөж, ангийн захирагчийн төрийн сурталчилгаа хүмүүжлийн ажил хариуцсан орлогч, штаб болон бусад албадтай хамтарч явуулна.

Хууль, эрх зүйн ажлын үндсэн зорилтууд нь:

- Улсын хилийн цагийн байдлын өөрчлөлтийн нөхцөлд бие бүрэлдэхүүний нийгмийн хэрэгцээ, санал хүсэлтийг судалж, түүнийг шуурхай шийдвэрлэх асуудлаар захирагч дарга нар саналаа тавих,
- Цэргийн албан хаагчид, тэдгээрийн гэр бүлийнхний хуулиар эдлэх эрх, хөнгөлөлтүүдийг эдлүүлэх, бололцоог хангах,
- Хууль ёс, дэг журам, сахилгыг бэхжүүлэхэд удирдлагын оновчтой шийдвэр гаргуулахын тулд бие бүрэлдэхүүний нийгмийн сэтгэл зүйг судалж үндэслэлтэй санал боловсруулах,
- Яам, агентлагууд, бусад субъектууд улсын хил, хязгаар нутгийн төр захиргаа олон нийтийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн удирдлагатай бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбоо тогтоож нягт хамтран ажиллах,
- Хороо, анги, салбаруудын амьдрал үйл ажиллагааны тулгамдсан асуудлуудаар олон түмний санаа бодлыг мэдэх зорилгоор социологийн судалгаа, асуулт, хариултын ажил зохион байгуулж явуулах,
- Хороо, анги, салбаруудад сахилга дэг журам, зохион байгуулалтын зохих түвшинг хангах, нэгтгэн захирах удирдлагыг хууль эрхийн үндсэн дээр бэхжүүлэх, цэргийн тангараг дүрмийн шаардлага, даргын үүрэг тушаалыг биелүүлэхийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх,

●Цэргийн албан хаагчдын эрх зүйн мэдээлэл хүмүүжлийн ажлыг зохион байгуулж тэдэнд хууль эрх зүйн зөвлөмж тусламж үзүүлэх,

Хууль, эрх зүйн ажлын үндсэн хэлбэр, аргууд нь:

●Цэрэг нийгмийн ажлын асуудлаар шийдвэр гаргахад нь захирагч / дарга/ нарт туслах зорилгоор санал бэлтгэх,

●Бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулж удирдлагад танилцуулах,

●Бие бүрэлдэхүүнтэй зохиох хууль, эрх зүйн ажилд шинэ технологи, менежментийн ашигтай хувилбарыг нэвтрүүлэх,

●Бүх зэрэг тушаалын цэргийн албан хаагчидтай хууль, эрх зүйн хүмүүжлийн иж бүрэн арга хэмжээг зохиож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах,

●Бүх шатны захирагч /дарга/ нар бие бүрэлдэхүүнийг хувийн асуудлаар хүлээн авч уулзах, арга зүйн зөвлөмж өгч туслах,

●Бие бүрэлдэхүүний өргөдөл, гомдолд хариу бэлтгэж өгөх,

●Цэрэг-социологийн судалгаа, санал асуулга явуулах засаар цэрэг нийгмийн ажлын тулгамдсан асуудлаар олон нийтийн санаа бодлыг байнга судлах,

●Хууль, эрх зүйн ажлын зорилтуудыг шийдвэрлэхэд төр засгийн болон орон нутгийн байгууллагуудтай байнгын харилцан ажиллагаатай байх,

●Хууль, эрх зүйн ажлын зорилтуудыг шийдвэрлэхэд нийтийн хүч чармайлт санаа бодлыг төвлөрүүлэх,

Амралт, чөлөөт цагаар зохиох ажил.

Амралт, чөлөөт цагаар зохиох ажил нь бие бүрэлдэхүүний амралт чөлөөт цагийг зөв боловсон зохион байгуулахад захирагч/дарга/ штаб сурталчилгаа, хүмүүжлийн байгууллагуудаас хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоо мөн.

Чөлөөт цагаар зохиох ажлын зорилтууд нь:

●Хил хамгаалах байгууллагуудыг соёл урлаг, уран сайхны үйлчилгээгээр хангах,

●Эх орныхоо болон дэлхийн соёлын оюуны үнэт зүйлсийг хилчдэд хүргэх,

●Цэргийн албан хаагчдын оюуны болон санаа сэтгэлийн байдлыг судлах, соёл амралтын ажлыг боловсронгуй болгох асуудлуудаар бодлого боловсруулж сурталчлах,

●Цэргийн үүрэг, дайчин уламжлалдаа үнэнч байх, эрэлхэг зоригтой шийдэмгий байж, ирээдүйдээ болоод хүчиндээ итгэх итгэлийг тэдний